

Аврагчийн Цагаатгал

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Дараах судрын хэсгүүд болон мэдэгдэл нь Есүс Христийн Цагаатгалын тухай заадаг. Эдгээр эх сурвалжийг (эсвэл Аврагчийн Цагаатгалын талаар сурч мэдэхийг хүссэн зүйлээ эсвэл энэ хичээлээс өмнө олсон бусад эх сурвалжийг) уншихад 10-аас 15 минут зарцуулна уу. Та уншиж байхдаа эдгээр эх сурвалж бүр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр таны төлөө юуг, яагаад хийснийг илүү сайн ойлгоход хэрхэн тусалж байгаа талаар бодоорой.

- Лук 22:39–44
- Лук 23:33–38, 44–46
- Иохан 3:14–17
- Алма 7:11–13
- 3 Нифай 27:14
- Сургаал ба Гэрээ 18:10–11
- Сургаал ба Гэрээ 19:16–19

Далын ахлагч Тэд Р.Каллистэр ийн заасан.



Тэгвэл Есүс Христийн Цагаатгал гэж юу вэ? Нэг талаас энэ нь Гетсеманийн цэцэрлэгээс эхлэн, загалмай дээр үргэлжилж мөн Аврагч булшнаас амилснаар оргилдоо хүрсэн, дараалсан үйл явдлууд юм. Энэ бол бидний хүн нэг бүрийг гэсэн цаглашгүй их хайраар хөглөгдөн хийсэн зүйл. Үүнийг хийхэд нүгэлгүй нэгэн байх мөн элементүүдийг байтугай үхлийг захирах хязгааргүй хүчтэй, бидний бүх гэм нүгэл хийгээд өвчин шаналын үр дагаврыг даван гарах дуусашгүй хүч чадавхтай, бүх зүйлийн доор бууж ирсэн нэгэн шаардлагатай байв [Сургаал ба Гэрээ 88:6-г үзнэ үү]. Энэ бол Есүс Христийн үйл хэрэг буюу Түүний Цагаатгал байсан.

Тэгвэл үүний зорилго юу байсан бэ? Энэ нь биднийг Бурханы оршихуйд эргүүлэн авчирч, Түүнтэй илүү адилхан болгох, баяр хөөрийн бүрэн байдлыг хүлээн авах боломжийг бидэнд олгох явдал байсан юм.

Үүнийг дараах дөрвөн саадыг давснаар гүйцэтгэсэн. Үүнд:

1. Бие махбодын үхэл
2. Адамын болон бидний гэм нүглийн улмаас ирэх сүнсний үхэл
3. Бидний зовлон, сул дорой чанар
4. Бидний сул тал ба төгс бус байдал

(Тэд Р.Каллистэр, “Есүс Христийн Цагаатгал,” *Ensign*, May 2019, 85 эсвэл 2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 103)